



20.24 он. 02 сар. 16 өдөр

№ 16/2024

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Моннаб” ХК -ийн хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Зөрчилгүй дүгнэлт

“Моннаб” ХК -ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Моннаб” ХК -ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлага энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Энэхүү компани нь бусад мэдээлэл буюу жилийн тайлан бэлтгэдэггүй.

Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас илэрхийлж байгаа мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, залилан болон алдаанаас үүдэх материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлж мөрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн

тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан болон алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлан бэлтгэх явдал юм. Ул үндэстэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа бүх буруу тайлагналыг үргэлж илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдлийг тодорхойлж үнэлэн, уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай нотолгоог олж авсан. Залилангаас үүдэлтэй материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах явдлууд орсон байж болно.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.

- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурьдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсч болох юм.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналт дахь зөрчил дутагдал, сул талуудыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлаар засаглах эрх бүхий этгээдтэй харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан компанийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ай Жэй Эй Эйч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2024.02.16


САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

/мянган.төгрөгөөр/

	2022	2023
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	18.9	18.9
Авлага	72,796.0	72,796.0
Татвар, НДШ-ийн авлага	82.6	82.6
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	25,459.4	25,459.4
Эргэлтийн хөрөнгийн дүн	98,356.9	98,356.9
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	19,785.0	19,785.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	19,785.0	19,785.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	118,141.9	118,141.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	102,621.8	102,621.8
Богино хугацаат өр төлбөр	36,202.6	61,994.3
Богино хугацаат өр төлбөрийн дүн	138,824.4	164,616.1
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	138,824.4	164,616.1
Эздийн өмч		
Өмч / төрийн /		
Өмч / хувийн /	12,276.7	12,276.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	95,895.2	95,895.2
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	(139,509.0)	(154,646.1)
Эздийн өмчийн дүн	(31,337.1)	(46,474.2)
Нийт өр төлбөр, өмчийн дүн	107,487.3	118,141.9

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно




ОРЛОГЫН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	2023
Борлуулалтын орлого	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-
Нийт ашиг (алдагдал)	-
Хүүний орлого	-
Борлуулалт маркетингийн зардал	-
Ерөнхий ба удирдлагын зардал	15,137.1
Санхүүгийн зардал	-
Бусад зардал	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (гарз)	-
Бусад ашиг /алдагдал/	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(15,137.1)
Орлогын татварын зардал	-
Татварын дараах ашиг (алдагдал)	(15,137.1)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(15,137.1)

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно




МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	2023
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	
Бусад мөнгөн орлого	
Мөнгөн зарлагын дүн (-)	15,137.10
Ажилчдад төлсөн	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	
Бараа материал худалдан авахад төлсөн	
Ашиглалтын зардалд төлсөн	
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	
Хүүний төлбөрт төлсөн	
Татварын байгууллагад төлсөн	106.40
Даатгалын төлбөрт төлсөн	-
Бусад мөнгөн зарлага	15,030.70
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,137.10)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	-
Хүлээн авсан хүүний орлого	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	15,137.10
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	15,137.10
Мөнгөн зарлагын дүн (-)	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-
Ханшийн зөрүүний гарз	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	15,137.10
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48.90
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18.90

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Моннаб” ХК нь үүсгэн байгуулагчийн 1996 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэр, баталсан дүрмийн дагуу 340 гишүүнтэй, хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан.

Компани нь орлого ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна. Үүнд:

- Барилга угсралтын ажил

ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

2.1 Нягтлан бодох бүртгэлийн үндэс

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон тус зөвлөлийн тайлангийн хорооноос гаргасан тайлбар болон Монгол улсын зохих хууль, тогтоомжийг үндэслэн бэлтгэсэн.

2.2 Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Санхүүгийн тайлангууд нь компанийн тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

2.3 Үнэлгээ

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэдэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн суурь

Компани нягтлан бодох бүртгэлийн аккурэль суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. Санхүүгийн тайлангууд нь, бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хэрэгслүүдээс бусад зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртгийн суурьт үндэслэн бэлтгэгдсэн.

2.5 Санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүн зэрэгт нөлөөлөх үнэлгээ, таамаглал ба тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийгдсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

2.6 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө нь касс дах бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дах харилцах дансуудаас бүрдэнэ. Мөнгө түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэдэг.

2.7 Бусад авлага

Байгууллага, иргэдэд буцаан төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон мөнгө, татвар, шимтгэлийн авлагыг бусад авлагаар бүртгэдэг. Эдгээр авлагыг тухайн үеийн нэхэмжлэх дүнгээр тайлагнадаг. Авлагын хувьд насжилт, цуглуулагдах магадлалыг үнэлэн найдваргүй авлагын нөөцийн сан байгуулдаггүй.

Худалдан авагчаас нэхэмжлэх дүн

Худалдан авагчаас нэхэмжлэх дүн нь худалдан авагчаас хараахан нэхэмжлээгүй боловч тухайн өдрөөрх гэрээт ажлын гүйцэтгэл бөгөөд худалдан авагчаас авахаар хүлээгдэж буй нийт дүнг илэрхийлнэ. Энэ нь нийт гарсан зардал дээр нэмэх нь тухайн өдрөөрх хүлээн зөвшөөрөгдсөн ашиг, хасах нь гүйцэтгэлийн хэмжүүрүүд болон тухайн өдрөөр хүлээн зөвшөөрөгдсөн алдагдал гэж хэмжигдэнэ. Нийт гарсан зардалд тухайн төсөлд шууд хамааралтай гарсан бүх зардал мөн үйл ажиллагааны хэвийн хүчин чадалд суурилан тооцож, хуваарилсан компанийн үйл ажиллагааны тогтмол ба хувьсах нэмэлт зардлуудыг багтаана. Худалдан авагчаас нэхэмжлэх дүн нь балансад дансны болон бусад авлагын хэсэгт тайлагнагдана.

Хэрэв харилцагчдаас хүлээн авсан төлбөр нь орлогын тайланд хүлээн зөвшөөрснөөс илүү байвал зөрүү нь худалдан авагчид өгөх өглөг болох ба балансад дансны болон бусад өглөг хэсэгт урьдчилж орсон орлогын адил тайлагнагдана.

2.8 Үндсэн хөрөнгө

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ.

Үл хөдлөх хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа үеэс дахин үнэлсэн үнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь бүртгэнэ.

Үл хөдлөх хөрөнгөөс бусад үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэтэй харьцуулж тодорхойлдог бөгөөд цэвэр дүнгээр орлогын тайланд "бусад олз/гарз"-аар хүлээн зөвшөөрдөг.

Хэрэв дахин үнэлсэн үндсэн хөрөнгийг борлуулах тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдэл санд байгаа дүнг хуримтлагдсан ашиг руу шилжүүлдэг.

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ дээр түүнийг олж бэлтгэхэд гарсан зардал, капиталжуулсан засварын зардлыг нэмсэн дүнгээс бүрддэг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна.

Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүнийг ашиглалтанд орсон хугацаанаас эхэлж, хөрөнгийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож байгуулдаг.

Элэгдэл тооцох арга болон хугацаа нь Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн заалтад нийцэх бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

<u>Үндсэн хөрөнгийн төрөл</u>	<u>ашиглагдах хугацаа (жилээр)</u>
Барилга, байгууламж	40
Уул уурхайн тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга, эд хогшил	10
Компютер, дагалдах хэрэгсэл	2
Бусад хөрөнгө	10

Үндсэн хөрөнгөнд хийсэн урсгал болон их засварын зардлыг засвар хийх тухай бүр тооцож бүртгэнэ.

Засварын зардал нь үндсэн хөрөнгийн анхдагч үнэлгээний үед тогтоосон бүтээмжийг дээшлүүлэхүйц, компанийн хүртэх ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхүйц, ашиглагдах хугацааг уртасгахаар байвал тэдгээрийг капиталжуулах ёстой. Бусад засварын зардлыг урсгал засвар гэх бөгөөд тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.

2.9 Дансны өглөг

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбогдон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зардыг хуримтлуулснаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.

Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

2.10 Татварын өглөг

Монгол улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын санд төлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

2.11 Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчээс оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийлдэг. Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дүн нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүн байна.

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь өмнөх болон тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

2.12 Борлуулалт маркетингийн зардал

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилсанаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Компанийн удирдлагын болон үндсэн үйл ажиллагаанд хамаарах зардлыг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрөх ба үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ногдох дүнгээр нь бүртгэдэг.

А.Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал

Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр төлөгдсөнөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Б.Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол улсын “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу компани ажиллагсдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын дүнгээс даатгуулагчаас 11.5 хувиар, ажил олгогчоос 12.5 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээдэг.

В.Нэмэгдсэн өртгийн албан татвар

Монгол улсын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ногдох бараа, ажил үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож НӨАТ төлдөг.

Мөн хуулиар НӨАТ ногдох бараа, ажил үйлчилгээний орлогын хэмжээ хуулийн этгээдийн орлогын албан татварын тайлангаар 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн өдрийн дараа сараас НӨАТ төлөгчөөр бүртгүүлдэг.

Үндсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний борлуулалтын орлого 50.0 сая төгрөгт хүрсэн эсэхээс үл хамааран Монгол улсад 2.0 сая ам.доллар ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээд сайн дураараа НӨАТ төлөгч болно.

ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС

Тайлант хугацааны эцсээрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

Үзүүлэлт	2022	2023
Кассанд байгаа бэлэн мөнгө	18.9	18.9
Бэлэн мөнгөний үлдэгдэл	18.9	18.9
Банкин дахь төгрөгийн дансны нийт дүн	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	18.9	18.9

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дахь төгрөгийн болон валютын харилцах дансуудаас бүрдсэн байна.

ТОДРУУЛГА 4. АВЛАГА

Үзүүлэлт	2022	2023
Дансны авлага	72,796.0	72,796.0
НӨАТ -ын авлага	82.5	82.5
Авлагын дүн	72,878.5	72,878.5

ТОДРУУЛГА 5. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ ТООЦОО

Үзүүлэлт	2022	2023
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	25,459.4	25,459.4
Урьдчилж төлсөн зардал/ тооцооны дүн	25,459.4	25,459.4

ТОДРУУЛГА 6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

А. Үндсэн хөрөнгийн тайлант оны хөдөлгөөнийг харуулбал дараах байдалтай байна.

	2022	2023
Барилга байгууламж	19,785.0	19,785.0
Үндсэн хөрөнгийн дүн	19,785.0	19,785.0

ТОДРУУЛГА 7. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2022	2023
Дансны өглөг	102,621.8	102,621.8
Бусад богино хугацаат өр төлбөр	36,202.6	61,994.3
Богино хугацаат өр төлбөрийн дүн	138,824.4	164,616.1

ТОДРУУЛГА 8. ХУВЬЦААТ КАПИТАЛ

	2022	2023
Хувийн өмч	12,276.7	12,276.7
Хувьцаат капиталын нийт дүн	12,276.7	12,276.7

Компаний хувь нийлүүлсэн хөрөнгө нь 12,276.7 мянган төгрөг байна

ТОДРУУЛГА 9. ХУРИМТЛАГДСАН АШИГ /АЛДАГДАЛ/

Үзүүлэлт	2022	2023
Тайлант үеийн ашиг	(139,509.0)	(154,646.1)
Хуримтлагдсан ашгийн дүн	(139,509.0)	(154,646.1)

ТОДРУУЛГА 10. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2022	2023
Албан татвар, төлбөр хураамж	9,068.8	13,474.1
Шуудан холбооны зардал	104.6	352.0
Бусад зардал	1,481.1	1,311.0
Үйл ажиллагааны зардлын дүн	10,654.6	15,137.1

ТОДРУУЛГА 11. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Тайлант хугацаанд 15,137.1 мянган төгрөгийн зардал гарж. (15,137.1) мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж орлогын татварын зардал төлөхөөр тооцоологдоогүй байна.

Бэлтгэсэн:

Аудитор


Аудиторын туслах



Н.Уранчимэг

Э.Нандин-Эрдэнэ

БАТЛАВ.



АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Нэг талаас “Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх), нөгөө талаас “Моннаб” ХК (цаашид “үйлчлүүлэгч” гэх) нар харилцан тохиролцсоны үндсэн дээр үйлчлүүлэгчийн 2023 оны жилийн санхүүгийн тайланд аудит хийх (цаашид “үйлчлүүлэгч” гэх) тухай энэхүү гэрээг 2024 оны 01-р сарын 22-ны өдөр байгуулав.

1. Үйлчилгээ

- a. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт 1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан ажил үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.
- b. Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчид үзүүлэхдээ Хавсралт 2-т тодорхойлсон “Гүйцэтгэгчийн ажиллах хүчний жагсаалт”-д заасан мэргэжилтнүүдийг ажиллуулах үүрэгтэй.

2. Хугацаа

Гүйцэтгэгч нь үйлчилгээг жилийн эцэст талуудын тохиролцсон өдрөөс эхлэн ажлын 2 хоног буюу ажлын 16 цагт багтаан хийж, аудиторын дүгнэлтийг 2024 оны 01 дугаар сарын 24-ны дотор үйлчлүүлэгчид хүргүүлнэ.

3. Төлбөр

- a) Төлбөрийн дээд хязгаар
Үйлчилгээний нэг баг цагийн ажлын хөлс 31 250 төгрөг байна. Үйлчилгээний хөлсөнд 2 ажлын хоног * 8 цаг * 31 250 = 500 000 төгрөг (таван зуун мянган) төгрөгийн төлбөр төлнө. Энэхүү дүнд НӨАТ ороогүй болно.

b) Төлбөрийн хуваарь

Гэрээнд гарын үсэг зурагдсан өдөр гэрээний урьдчилгаа төлбөрт 60 % төлнө, аудиторын дүгнэлтийг хүргүүлсэн өдөр үлдсэн 40 % төлнө.

4. Тайлагнал

Тайлангууд

Гүйцэтгэгч нь Үйлчлүүлэгчийн ажлын даалгаварт заасан тайлангуудыг гэрээнд заасан хугацаанд гаргаж ирүүлэх ба энэ нь 3-р зүйлд заасан төлбөрийг хийх үндсийг бүрдүүлнэ.

5. Гүйцэтгэх стандарт

Гүйцэтгэгч нь үйлчилгээг мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар хийж гүйцэтгэх үүрэгтэй. Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчээс хангалтгүй үнэлгээ авсан багийн гишүүнийг нэн даруй солино.

6. Нууцлал

Гүйцэтгэгч нь Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад, мөн түүнийг дуусгавар болсон хугацаанаас хойш 2 жилийн дотор уг үйлчилгээ, гэрээ, үйлчлүүлэгчийн өмчлөлийн болон үйл ажиллагаатай холбоотой нууц материалыг задруулах эрхгүй.

7. Материал эзэмших эрх

Үйлчлүүлэгч нь гүйцэтгэгчийн санхүүгийн баримт болон аудит хийхтэй холбоотой бусад мэдээллээр хангаж өгнө. Материалын жагсаалтын дагуу мэдээллээр хангана. Энэхүү гэрээний дагуу үйлчлүүлэгчид зориулан бэлтгэсэн аливаа судалгааны болон бусад эх материал, зураг график, аргачлал, загвар зэрэг нь Үйлчлүүлэгчийн эзэмшилд хамаарагдах ба Гүйцэтгэгч нь эдгээр баримт болон программ хангамжийн хувийг авч болно.

8. Гүйцэтгэгчийн оролцож болохгүй ажил

Энэхүү гэрээний хугацаанд буюу гэрээ дуусгавар болсны дараа гүйцэтгэгч нь үйлчилгээтэй холбоогүй өөр бусад бараа, үйлчилгээ үзүүлэхгүй байхыг зөвшөөрч байгаа бөгөөд үйлчлүүлэгчийн холбогдох этгээдтэй эрх ашгийн зөрчилдөөнгүй, холбогдох этгээдтэй аливаа холбоогүй, хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулна.

9. Даатгал

Гүйцэтгэгч нь аудитын хариуцлагын даатгалд даатгуулах асуудлаа хариуцна

10. Гүйцэтгэгчийн хариуцлага

Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд гаргасан дүгнэлтийн хүрээнд хариуцлага хүлээнэ.

11. Эрх шилжүүлэлт

Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэх, эсвэл түүний аливаа хэсгийг туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхгүй.

12. Үйлчлүүлэгчийн эрх

Аудитороос гаргасан дүгнэлтийнхээ үндэслэлийг тайлбарлахыг шаардах эрхтэй.

Гаргасан дүгнэлт нь үндэслэлгүй, шаардлага хангаагүй, шалгалтыг дутуу хийсэн гэж үзвэл зөрчлийг арилгуулах хүсэлт гаргах, удирдлагад нь мэдэгдэх, өөр аудитор гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

Аудитын дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол энэ талаар гуравдагч этгээдээр шалгуулах, шүүхэд гомдол гаргах эрхтэй.

13. Маргаан шийдвэрлэх

Үйлчлүүлэгч нь гүйцэтгэгчийн гаргасан дүгнэлтэнд тайлбар өгөхийг шаардах, дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол захиалагчид гомдол гаргах эрхтэй. Энэ гэрээний нөхцөлүүдийг зөрчсөн буюу ажлын гүйцэтгэлтэй холбоотой аливаа зөрчил шийдвэрлэх, зөвшилцөлд хүрч чадахгүй тохиолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

“Ай Жэй Эй Эйч” ХХК-ийг төлөөлж:

Менежер.....

Утас: 95830023

“Моннаб” ХК-ийг төлөөлж:

Менежер.....

Утас: 51919392



Зөвлөх үйлчилгээ үзүүлэх
 _____ тоот гэрээний хавсралт

Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ

Гүйцэтгэх ажлууд	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах ажилтан
А. Үйлчлүүлэгчийн тухай ойлголт олж авах		Н.Уранчимэг
1. Компаний тухай мэдээлэл олж авах		Н.Уранчимэг
2. Эхний уулзалт ярилцлага		Н.Уранчимэг
➤ Гэрээт ажлын рискийг үнэлэх		Н.Уранчимэг
➤ Өмнөх үеийн аудитлагдсан болон аудитлагдаагүй санхүүгийн тайлан, төсөв ба хэтийн төлөвлөгөө, Сар бүрийн үйл ажиллагааны тайлан, тусламж болон зээлийн гэрээ, хандивлагчдын хийсэн үнэлгээ, зохицуулагч байгууллагаас хийсэн шалгалт болон захидал харилцаа зэргийг шалгах		Н.Уранчимэг
3. Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон арга зүйн талаарх ойлголт олж авах		Н.Уранчимэг
➤ Нягтлан бодох бүртгэлийг ямар стандартын дагуу хийсэн талаар		Н.Уранчимэг
➤ Арга зүйн үндсэн суурийг тогтоох		Н.Уранчимэг
4. Нягтлан бодох бүртгэлийн болон дотоод хяналтын системийн талаарх ойлголт		Н.Уранчимэг
➤ Үйл ажиллагааны ажил гүйлгээний ерөнхий ангилал, хэр зэрэг ажил гүйлгээ хийсэн, бүртгэл, туслах мэдээлэл, санхүүгийн тайлангийн тооцоо, тайлагнасан үйл явц зэргийн талаар ойлголттой болох		Н.Уранчимэг
➤ Дотоод хяналтын системд гаднаас хяналт тавих		Н.Уранчимэг
5. Аудитын эрсдлийг үнэлэх		Н.Уранчимэг
➤ Уламжлалт эрсдлийг үнэлэх		Н.Уранчимэг
➤ Хяналтын эрсдлийг үнэлэх		Н.Уранчимэг
➤ Илрүүлсэн эрсдлийг үнэлэх		Н.Уранчимэг
6. Материаллаг байдлын төвшинг тогтоох		Н.Уранчимэг
7. Дотоод аудитортай холбоо тогтоох ба үйл ажиллагааг нь үнэлэх		Н.Уранчимэг
8. Аудитын дэлгэрэнгүй хөтөлбөр боловсруулж, батлах		Н.Уранчимэг

Б.Аудит нотолгоо олж авах ба аудит гүйцэтгэх үйл ажиллагаа		Н.Уранчимэг
➤ Дансны жагсаалт олж авах		Н.Уранчимэг
➤ Дансны үлдэгдэл бүрийн хувьд байж болох алдааг олж тогтоох		Н.Уранчимэг
➤ Дансны үлдэгдэл бүрийн хувьд эрэдлийг тодорхойлох (зээл, хүүгийн түвшин, заль мэх, ханшийн рискүүд)		Н.Уранчимэг
➤ Хяналтын тест гүйцэтгэх (Дотоод хяналт, санхүүжилт, зарцуулалт хийх хяналтын тест, үйлчлүүлэгчийн ажлын байранд хийх хяналт)		Н.Уранчимэг
➤ Биет шалгалт хийх, (Нарийвчилсан шалгалт ба шинжилгээний горимууд гүйцэтгэнэ.)		Н.Уранчимэг
➤ Түүврийн хэмжээ тодорхойлох		Н.Уранчимэг
➤ Удирлагын төлөөллийн захидал олж авах		Н.Уранчимэг
В. Ажлын баримтыг үнэлэх ба тайлагнах		Н.Уранчимэг
➤ Аудитын явцад олж авсан ажлын баримтуудыг үнэлэх		Н.Уранчимэг
➤ Удирлагад хандсан төлөөллийн захидал бэлтгэж, үйлчлүүлэгчид хүргүүлэх		Н.Уранчимэг
➤ Аудиторын тайлан бэлтгэх		Н.Уранчимэг
➤ Аудиторын тайлангийн хувилбарыг үйлчлүүлэгчид илгээх		Н.Уранчимэг
➤ Удирдлагад хандсан зөвлөмж захидал бэлтгэж, үйлчлүүлэгчид хүргүүлэх		Н.Уранчимэг
➤ Аудиторын тайланг эцэслэн бэлтгэж, үйлчлүүлэгч болон холбогдох талуудад хүргүүлэх		Н.Уранчимэг

АУДИТЫН АЖЛЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог нэр	Албан тушаал	Багийн ажилд гүйцэтгэх үүрэг
1	Г.Энхмаа	Захирал, ахлах аудитор	Аудитын багийн ажлын хуваарилалт, үе шатны ажлын хяналт, багийн ахлагч
2	Н.Уранчимэг	Ахлах аудитор	Гадаад дотоод орчны нөлөөлөл, удирдлага, хариуцлагын тогтолцоо тэдгээрийн сул болон давуу тал, нөөцийн мэдээлэл зэргийг сайтар судалж, аудит хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулж, аудитын зорилго, цар хүрээ, материаллаг байдал, эрсдлийг тодорхойлно.
3	Э.Нандин-Эрдэнэ	Аудиторын туслах	СТОУС, АОУС-ыг мөрдлөгөө болгон, ёс зүйн дүрмийг биелүүлж ажиллана.
4	Р.Алтанцэцэг	Аудитын менежер	Гэрээ биелэлт, ажлын хуваарилалт, чиг үүргээр хангаж ажиллана. Аудитад гарах зардлын тооцоог хийнэ.
5	Л.Оюунцэцэг	Чанарын хяналтын ажилтан	Чанарын хяналт